Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ГААЛИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ О.ДОРЖХАНДЫН 2024 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|---|
| | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| НЭГ. “УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ШУДАРГА, ҮР АШИГТАЙ, ҮР ДҮНТЭЙ БҮРДҮҮЛЭХ ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
| 1 | Бараанд гаалийн зорилгоор магадлан шинжилгээ хийх | 1. Хураамжийн орлогын төлөвлөгөө төгрөгөөр, хувиар<br>2. Зөрчил илрүүлэлт, тоогоор | Бүтэн жилд:<br>1. Улсын төсвийн өөрийн орлогын хуваарийн дагуу магадлан шинжилгээг хууль тогтоомжийн дагуу хийж, шинжилгээний хураамжаар 28 сая төгрөгийг улсын төсөвт оруулсан байна. (I-IV улирал)<br>2. Магадлан шинжилгээний явцад илэрсэн зөрчлийн тоо, өмнөх оноос буурч ажилласан байна. (I-IV улирал) | 1. Харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн химийн бодис, согтууруулах ундааны болон хүнсний бэлдмэлийн нийт дээжинд гаалийн зорилгоор магадлан шинжилгээг хууль тогтоомжийн дагуу хийж, дүгнэлт гаргаж, улсын төсөвт шинжилгээний хураамжаар төгрөгийн орлого оруулсан.<br><br>*Албан хүсэлтээр:* Тайлант хугацаанд удирдлагаас өөрт хуваарилагдсан 59 дээжинд холбогдох стандартын дагуу шинжилгээг хийж, барааны ангиллын кодыг тодорхойлж, улсын төсөвт төгрөгийн орлого оруулсан.<br>Нийт шинжилгээний хураамжаар төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж ажилласан.<br>2. Тайлант хугацаанд гаргасан магадлан шинжилгээнд хамрагдсан барааны шинжилгээний үр дүнгээр 4ААН-ийн 6ш дээжинд зөрчил илэрсэн. Нийт зөрчлийн 20%-ийг барааны ангиллын кодыг буруу мэдүүлсэн зөрчил ээлж байна. |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10<br>Биелэлтийн хувь: 100 |
| ХОЁР. “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Лабораторийн чадавхжуулалт /1.4.36/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, Магадлан шинжилгээнд зарцуулах хугацаа хоногоор | 1. Замын-Үүд, Гашуунсухайт, Хөшигтийн хөндий, Сэлэнгэ дэх гаалийн салбар лабораторийг химийн шинжилгээний чиглэлээр өргөжүүлж, суурилуулсан тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, ашиглалттай холбоотой үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, харилцан мэдээлэл солилцож ажиллана. (I-IV улирал)<br>2. Гаалийн төв болон салбар лабораториудад импортын хими, хүнсний бэлдмэлийн шинжилгээг хийсэн байна. (I-IV улирал)<br>3. ГТЛ болон ГСЛ-д хими, хүнсний бэлдмэлийн магадлан шинжилгээг хийж гүйцэтгэснээр нийт дээжний тоог 10-15 хувиар нэмэгдлүүлж, магадлан шинжилгээнд хамрагдах хугацааг 2-3 хоногоор бууруулна. (I-IV улирал) | 1. Замын-Үүд, Хөшигтийн хөндий, Сэлэнгэ дэх гаалийн салбар лабораторийг химийн шинжилгээний чиглэлээр өргөжүүлж, шинээр суурилуулагдсан орчин үеийн өндөр мэдрэмжит [redacted] багажны тоног төхөөрөмжийн хэвиин ажиллагаа, ашиглалттай холбоотой үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, харилцан мэдээлэл солилцож ажилласан.<br>Сэлэнгэ дэх гаалийн салбар лабораторийн чанарын гарын авлага болон шинээр суурилуулагдсан тоног төхөөрөмжийн ТАЗ, САЗ боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, чадавхжуулж хамтарч ажилласан.<br>(I-IV улирал)<br>2. Гаалийн төв лабораторийн химийн шинжилгээг өргөтгөх чиглэлээр орчин үеийн өндөр мэдрэмжит [redacted] багажны шалгалт тохируулгыг хийн, багажны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, бүртгэлжүүлж ажилласан.<br>3. ГТЛ болон ГСЛ-д хими, хүнсний бэлдмэлийн шинжилгээг хийж гүйцэтгэснээр нийт дээжний тоог 10-15 хувиар нэмэгдлүүлж, магадлан шинжилгээнд хамрагдах хугацааг 2-3 хоногоор бууруулсан байна. (I-IV улирал) | |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:100 |
| 3 | Итгэмжлэлийн хүрээ өргөтгөх, чанарын менежментийн тогтолцоо /1.4.36/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Гаалийн төв лабоараторийн химийн шинжилгээний чиглэлээр өргөтгөх ажилд оролцож ажилласан байна. (I-IV улирал)<br>2.Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх, лабораторийн мэдээллийн менежментийн систем/LIMS/-ийг гаалийн төв лабораторийн үйл ажиллагаанд химийн шинжилгээний програмын чиглэлээр хөгжүүлж, химийн шинжилгээний хэсэг /LIMS/ програмд нэвтэрсэн байна. (I-IV улирал)<br>3.ОРГГ, ЗҮГГ, ДоГГ, Хөшигтийн хөндийн салбар лабораториудын тоног | 1. Гаалийн төв лабораторийн химийн шинжилгээг өргөтгөх чиглэлээр орчин үеийн өндөр мэдрэмжит [redacted] багажны шалгалт тохируулгыг хийн, багажны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, бүртгэлжүүлж ажилласан.<br>2.Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх, лабораторийн мэдээллийн менежментийн систем/LIMS/-ийг гаалийн төв лабораторийн үйл ажиллагаанд химийн шинжилгээний програмын чиглэлээр хөгжүүлэхэд LIMS-ийн багийнханд химийн ажлын хуудсын сорилтын тайланг гаргаж өгч, нэвтрүүлж ажилласан .<br>3. ОРГГ, ЗҮГГ, ДоГГ-ийн салбар лабораториудын тоног төхөөрөмжийн химийн шинжилгээний үр дүнг лабораторийн мэдээллийн менежментийн систем(LIMS)-д нэвтрүүлж ажилласан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төхөөрөмжийн химийн шинжилгээний үр дүнг лабораторийн мэдээллийн менежментийн систем(LIMS)-д нэвтрүүлж эхэлсэн байна. (I-IV улирал) | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:99 |
| 4 | Мэргэшсэн чадварлаг боловсон хүчингээр хангах, сургалтуудыг зохион байгуулсан ажил /1.4.6/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Төв болон салбар лабораторийн боловсон хүчнийг бэлтгэх, шинжээчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамрагдах, магадлан шинжилгээнд хамруулах, дээж авах чиглэлд зааварчилгаа өгөхөд оролцох (I-IV улирал) | 1.ГЕГ-ын ЗУГ-аас зохион байгуулсан цаг үеийн шинжтэй сургалтууд болон мэдээллийн цагт тухай бүр 100% тасалтгүй хамрагдаж, өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэн ажилласан.<br>2. Дэлхийн гаалийн байгууллагын ''Бүс нутгийн гаалийн лабораторийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх сургалт''-ын сонгон шалгаруулалтанд тэнцэж, 2024.10.14-2024.10.18-ны өдрүүдэд Дэлхийн гаалийн байгууллагад барааны ангиллын чиглэлээр, 2024.10.21-2024.11.28-ны өдрүүдэд Солонгосын гаалийн төв лабораторид шинжилгээний чиглэлээр тус тус мэргэжил дээшлүүлж ажилласан.<br>3. СЭГГ-ын салбар лаборатори, ДоГГ-ын салбар лаборатори, ОРГГ-ын салбар лаборатори, ЗҮГГ-ын салбар лабораторийн химийн шинжилгээ хийдэг боловсон хүчнүүдийн ур чадварыг сайжруулах зорилгоор, шинжилгээний болон гаалийн хэргийн чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж ажилласан. | |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:100 |
| 5 | Лабораторийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт, урвалж бодисын нийлүүлэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | . Хариуцсан химийн шинжилгээний тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээг хийлгэх, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, химийн бодисын сарын мэдээ тайланг гаргаж ажилласан байна. (I-IV улирал)<br>2.ГТЛ болон салбар лабораторийн химийн шинжилгээнд ашигласан урвалж бодисын тооцоо тайланг гаргах, шаардлагатай урвалж бодис, туслах хэрэгслийг хангахад оролцох, хэвийн үйл ажиллагааг хангах асуудлаар удирдлагад тавьж шийдвэрлүүлнэ. (I-IV улирал) | 1. Гаалийн төв лабораторийн химийн шинжилгээнд ашиглагддаг НУТ, РАМАН-ны хосолсон спектрометр багажны ашиглалт хамгаалалтад хяналт тавьж, шинжилгээнд ашигласан тоног төхөөрөмжийн цагийн бүртгэлийг тогтмол хөтлөн, засвар үйлчилгээг хийлгэх үед тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортод тухай бүр тэмдэглэл хөтлөн бүртгэлжүүлэн ажилласан.<br>-Гаалийн газар, хороодоос төв лабораторийн магадлан шинжилгээнд хамрагдахаар ирүүлсэн химийн бодисын дээжүүдийн мэдээ тайланг барааны нэр төрөл тус бүрээр 1-10 сараар нэгтгэн гарган, статистикийн хэлтэст сар бүрийн 05-ны дотор тухай бүр хүргүүлж ажилласан.<br>2. 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гаалийн төв болон салбар лабораторид нэн шаардлагатай химийн бодисын багажны чийг баригч болон шинжилгээнд нэн шаардлагатай шил сав, урвалж, тоног төхөөрөмж, туслах | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хэрэгслүүдийн үнийн судалгааг гарган захиалуулж, төсөвт суулгуулж ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 Биелэлтийн хувь:99 |
| 6 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт /1.4.8/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Гаалийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтөнд, УИХ, ЗГ болон Сангийн сайдын тогтоол шийдвэрийн нэмэлт өөрчлөлтөнд санал өгч батлуулж ажилласан байна. (I-IV улирал)<br>2. Гаалийн лабораторийн үйл ажиллагаатай холбоотой стандарт, холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж удирдлагаар батлуулж биелэлтийг хангаж ажилласан байх. (I-IV улирал) | 1. Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулагад хөдөлмөрийн нөхцөл, ажлын цаг ашиглалтын талаар саналаа өгч ажилласан. Үүнийн үр дүнгээр ГТЛ-ийн ажилчид хортой нөхцөлийн 10%-ийн нэмэгдэл цалин авах боломжтой болсон.<br>2.Гаалийн лабораторийн бодлогын /эрх зүйн/ бичиг баримт болон чанарын менежентийн тогтолцоотой холбоотой журмууд, холбогдох бичиг баримтуудад нэмэлт өөрчлөлтөд оруулахтай холбоотой “Бараанаас сорьц дээж авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ыг шинэчлэн найруулах төсөлд химийн шинжилгээтэй холбоотой стандарт, холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах саналд саналаа өгч, биелэлтийг хангаж ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 Биелэлтийн хувь: 99 |
| 7 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт /1.4.29/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Гаалийн лабораторийн хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчилан таниулах, хэрэгжилтийг хангах ажилд тухай бүр оролцож ажилласан байна. (I-IV улирал)<br>2. Гаалийн лабораторийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг өдөр бүр хангаж ажилласан байна. (I-IV улирал) | 1. Гаалийн лабораторийн хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах ажилд тухай бүр оролцсон.<br>- ГТЛ-д харьяа гаалийн газар хороо, төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс ирсэн албан тоотуудын хариуг тухай бүр түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан .<br>- Шинэчлэн батлагдсан “Бараанаас сорьц, дээж загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>2.-Тайлант хугацаанд Гаалийн төв лабораторийн химийн шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн ажиллах заавар, зааварчилгаа, техник үйл ажиллагаа, үзүүлэлтийг сурталчилан танилцуулан ажилласан.<br>- Мөн Гаалийн төв лабораториар үйлчлүүлж буй ААН, иргэдэд лабораторийн шинжилгээнд хамрагдах барааны жагсаалт, дүгнэлт гаргахад шаардлагатай баримт бичгийн жагсаалт, шинжилгээний төлбөр, лабораторийн болон гаалийн хэргийн мэдлэгтэй холбоотой хууль тогтоомжууд болон химийн шинжилгээний үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг ажлын 351975, 70114026 утсаар, http://www.customs.gov.mn/, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | spark цахим мэдээллийн эх сурвалжаар болон амаар тайлбар өгч ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 — Биелэлтийн хувь: 100 |
| 8 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал /1.4.33/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх | 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр шинэчлэн батлагдсан ***А/422*** "Бараанаас сорьц, дээж загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-ын дагуу ГТЛ-ийн химийн шинжилгээнд хамрагддаг жижиглэн худалдахаар савлагдсан бэлэн бүтээгдэхүүнд эрсдэл тооцож хамруулах саналаа өгч ажилласан.<br>"Гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулах журам", "Гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулах журмын аргачлал"-ын төсөлд өөрийн саналаа өгч ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 — Биелэлтийн хувь:100 |
| 9 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, түүний хэрэгжилт /1.4.8/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Гаалийн лабораторийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлж, биелэлтийг хангаж, тайлагнаж ажилласан байна. (I-IV улирал)<br>2. Гаалийн лабораторийн удирдлагын өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн дагуу харьяа гаалийн газар хороод болон салбар лабораториудад химийн шинжилгээний чиглэлээр заавар зөвлөгөө, зөвлөмж хүргүүлж, ажилласан байна. (I-IV улирал) | 1.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж, хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:<br>- Гаалийн газар, хороодоос төв лабораторийн магадлан шинжилгээнд хамрагдахаар ирүүлсэн химийн бодисын дээжүүдийн 1-10-р сарын мэдээ тайланг барааны нэр төрөл тус бүрээр сараар нэгтгэн гарган, статистикийн хэлтэст сар бүрийн 05-ны дотор тухай бүр хүргүүлж ажилласан.<br>- Харьяа гаалийн газар, хороодоос магадлан шинжилгээгээр ирүүлсэн химийн бодис болон бусад барааны дээжүүдэд шинжилгээг түргэн шуурхай хийж, дүгнэлт гарган хариуг холбогдох гаалийн газар, хороод руу програмаар илгээн хамтран ажилласан.<br>- Шинжилгээнд хамрагдсан дээжний тооцоот хуудасны мэдээ тайланг нэгтгэн гаргаж, холбогдох файлыг нярав Б.Галбаатарт хүлээлгэн өгч тухай бүр хүргүүлж ажилласан.<br>- Өөрт хувиарлагдсан албан байгууллагийн нийт дээжийн шинжилгээг хийж, албан бичгийн хариуг удирдлагаар хянуулан, баталгаажуулж, хариуг хүргүүлж ажилласан.<br>- ЗҮГГ, СЭГГ, ДоГГ, ОРГГ-ын гаалийн салбар лабораториудыг химийн шинжилгээний чиглэлээр гадаад, дотоод хяналтанд хамруулж, шинжилгээний үр дүнг боловсруулж удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.<br>2. 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр шинэчлэн батлагдсан ***А/422*** "Бараанаас сорьц, дээж загвар авах, магадлан шинжилгээ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хийх, дүгнэлт гаргах журам"-талаар харьяа гаалийн газар, хороодын хяналтын болон салбар лабораторийн ГУБ нарт заавар, зөвлөгөө, зөвлөмжийг утсаар болон дотоод сүлжээ /spark/-ээр өгч, хамтарч ажилласан.<br>СЭГГ-ын салбар лаборатори, ДоГГ-ын салбар лаборатори, ОРГГ-ын салбар лаборатори, ЗҮГГ-ын салбар лабораторийн ГУБ нарт химийн шинжилгээний чиглэлээр заавар зөвлөгөө, зөвлөмж хүргүүлж, ажилласан. | |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:100 |
| 10 | Ажлын цаг ашиглалтыг сайжруулах /1.4.6/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажлын цаг ашиглалтыг гаргаж, илүү цагаар ажилласан тооцоог улирал бүр гаргах. (I-IV улирал)<br>2. Гаалийн төв лабораторийн шинжээч-гаалийн улсын байцаагч нарын хөдөлмөрийг хэвийн бус нөхцлийн 10%-ийн цалинг сар бүр тооцуулан, хор саармагжуулах бүтээгдэхүүнийг 7 хоног бүр авч хэрэглэж хэвшсэн байна. | 1.Ажлын цаг ашиглалтыг бүрэн хангаж ажилласан байна.<br>Үүнд:<br>- өвчтэй цаг -0,<br>- чөлөөтэй цаг-259 цаг /ГЕГ-ын даргын тушаалаар Дэлхийн гаалийн байгууллагад сургалтанд хамрагдсан/,<br>- илүү цаг -222.45 цаг<br>2. ГТЛ-ийн хор саармагжуулах арга хэмжээнд бүрэн хамрагдаж, хор саармагуулах бүтээгдэхүүнийг тухай бүр авч ажилласан. | |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | Үндсэн шалгуурт заагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.33/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. Гаалийн төв болон салбар лабораториудын шинжилгээний үр дүнгийн чанар хангалтыг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоод хяналтыг улирал бүр зохион байгуулах, лабораторийн ур чадварын сорилтод төлөвлөгөөний дагуу хамрагдаж ажилласан байна. Шинжилгээний зөрүү стандарт хязгаараас хэтрэхгүй байна. (I-IV улирал) | 1. 2024 оны бүтэн жилийн байдлаар ГТЛ-ийн гадаад, дотоод хяналтын шинжилгээний хуваарийн дагуу химийн бодисын шинжилгээний чиглэлээр ГТЛ-ийн ГУБ-Шинжээч Н.Мөнх-Учрал, Б.Сувд-Эрдэнэ, Д.Лхагвасүрэн, Б.Цогтгэрэл нартай химийн бодисын нийт 16 дээжинд дотоод хяналтын шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Дотоод хяналтын шинжилгээний үр дүнгийн харьцуулалтаас үзэхэд Ж707 "Шинжилгээний үр дүнгийн чанар хангалтын дотоод журам"-ын шаардлагыг хангаж байсан.<br>-Харьяа гаалийн газрын салбар лабораторийн чанар хангалтыг хянах зорилгоор химийн бодисын 22 дээжинд хяналтын шинжилгээг хийж гүйцэтгэсэн.<br>Салбар лабораторийн хяналтын шинжилгээг үр дүнгийн харьцуулалтаас үзэхэд шинжилгээний үр дүнгийн зөрүү зөвшөөрөгдөх хязгаарт байсан.<br><u>*- Гадаад хяналтанд:*</u> Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас ирүүлсэн химийн бодисын 14 дээжинд хяналтын шинжилгээг хийж гүйцэтгэсэн.<br>Гадаад хяналтын шинжилгээний үр дүнгийн харьцуулалтаас үзэхэд "Шинжилгээний үр дүнгийн чанар хангалтын журам"-ын шаардлагыг хангаж байсан.<br>2. Гаалийн төв болон салбар лабораториудад ISO 17025: 2018 стандартын дагуу зохион байгуулагдах дотоод аудитад химийн шинжилгээний чиглэлээр хамрагдсан байна. Илэрсэн үл тохирлыг залруулах арга хэмжээг авч ажилласан байна. | |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:100 |
| 12 | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | - 2024 оны ажилтаны ХАСХОМ-оо 2024.02.05-ны дотор цаг хугацаанд нь гарган өгч ажилласан.<br>-Энэхүү ажлын хүрээнд химийн шинжилгээний ажлын цаг зарцуулалтын хугацааг шинжилгээ тус бүрээр гаргаж, удирдах албан тушаалтанд танилцуулж, хамтарч ажилласан.<br>-2024.02.02-ны өдрийн мэдээллийн цагаар Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ажилтан Б.Саруулзаяа "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргахад анхаарах зарим асуудал" сэдэв сургалтад хамрагдсан. | |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:100 |
| 13 | Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах | ***А/315*** "Бараанаас сорьц, дээж загвар авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам"-талаар хамтран ажилладаг ААН, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | албан байгууллагад заавар, зөвлөгөө, зөвлөмжийг цахим мэдээллийн эх сурвалжаар болон ажлын 351975, 70114026 утсаар амаар тайлбар өгч ажилласан.<br>Тайлант хугацаанд ААН, албан байгууллага, иргэдээс ирүүлсэн дээжинд хими, хүнсний бэлдмэлийн шинжилгээг хийхэд гомдол гараагүй, хэрэглэгчийн сэтгэл ханамж өндөртэй ажилласан. | |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:100 |
| **ГУРАВ.“ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | |
| 1 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан биелэлтийг ханган ажилласан байна. /I-IV улирал/<br>2.ГЕГ-ын ЗББНДБ-ын албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах болон эхний хагас жилийн биелэлтийг дүгнүүлэх ажлыг зохион байгуулсан байна. /I-IV улирал/ | 1. ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан биелэлтийг ханган ажилласан.<br>1.ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, удирдлагаар батлуулсан бөгөөд эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хуулийн хугацаанд удирдлагад өгч ажилласан. | |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 | Биелэлтийн хувь:100 |
| 2 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан | 1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу гаалийн байгууллага ирүүлсэн гаалийн төв лабораторийн удирдлагын цохолтоор ирүүлсэн албан бичиг дотоод зурваст тухай бүр хуулийн хугацаанд нь албан тоотоор хариу өгч ажилласан. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн хэвийн бус хортой нөхцөлийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажилласан байна. /I-IV улирал/ | 2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь гаргаж өгч ажиллалаа.<br><br>3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэд, ААН-ийн ГТЛ-д дүгнэлтийн хугацааг сунгуулах, шинжилгээ хийлгэх тухай хүсэлтээр ирүүлсэн албан бичгийг тухай бүр шийдвэрлэн, удирдлагаар хянуулж, хүргүүлэн ажиллалаа. |
| | | | | Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 — Биелэлтийн хувь: 100 |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 |
| НЭГ. "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 1 | Гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх болон цаг үеийн шинжтэй сургалтуудад удирдлагын үүрэг болгосны дагуу хамрагдаж ажилласан байх, хууль эрх зүйн мэдлэг чадвараа сайжруулах | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | - ГЕГ-аас зохион байгуулсан цаг үеийн шинжтэй мэдээллийн цаг болон цахим сургалтуудад тухай бүр 100% хамрагдаж, гаалийн хэргийн мэдлэг чадвараа дээшлүүлэн ажилласан.<br><br>- Дэлхийн гаалийн байгууллагын "Бүс нутгийн гаалийн лабораторийн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх сургалт"-ын сонгон шалгаруулалтанд тэнцэж, 2024.10.14-2024.10.18-ны өдрүүдэд Дэлхийн гаалийн байгууллагад барааны ангиллын чиглэлээр, 2024.10.21-2024.11.28-ны өдрүүдэд Солонгосын гаалийн төв лабораторид |

| | | | |
|---|---|---|---|
| | | | шинжилгээний чиглэлээр тус тус мэргэжил дээшлүүлж ажилласан.<br>- Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор “Шихихутуг хууль зүйн” их сургуульд докторантураар суралцаж байна.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 Биелэлтийн хувь:100 |
| 2 | Химийн шинжилгээний чиглэлээр сургалтуудад бие даан хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх | Химийн шинжилгээний чиглэлээр сургалтуудад бие даан хамрагдаж, ур чадвараа сайжруулж ажилласан байна.. | 2024.10.21-2024.11.28-ны өдрүүдэд Солонгосын гаалийн төв лабораторид химийн шинжилгээний чиглэлээр мэргэжил дээшлүүлж, мэдлэг чадвараа дээшлүүлэн ажилласан.<br>Тайлант хугацаанд химийн шинжилгээнд ашиглагддаг багаж, тоног төхөөрөмжүүдийг бие даан судлаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн ажилласан.<br><br>Эхэлсэн, дууссан огноо: 2024.01.01-12.10 Биелэлтийн хувь:100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ-ШИНЖЭЭЧ О. ДОРЖХАНД / ......О. Доржханд...... / ...2024... ...12... .........

(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ О.ДОРЖХАНДЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Гаалийн төв лаборатори

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх** | | | | | |
| 1. | Бараанд магадлан шинжилгээ хийх, илрүүлсэн зөрчил | 54 | 9 | 63 | |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | |
| 1 | Лабораторийн чадавхжуулалт | **48** | **8** | **56** | |
| 2 | Итгэмжлэлийн хүрээний өргөтгөл, чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх | **54** | **9** | **63** | |
| 3 | Мэргэшсэн чадварлаг боловсон хүчингээр хангах, сургалтуудыг зохион байгуулсан ажил | **60** | **10** | **70** | |
| 4 | Лабораторийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалт, урвалж бодисын нийлүүлэлт | **48** | **8** | **56** | |
| 5 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | **48** | **8** | **56** | |
| 6 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | **54** | **9** | **63** | |
| 7 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | **48** | **8** | **56** | |
| 8 | Үүрэг даалгаврын биелэлт | **54** | **9** | **63** | |
| 9 | Ажлын цаг ашиглалт | **54** | **9** | **63** | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Дотоод гадаад хяналт/ | 54 | 9 | 63 | |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах/ | 54 | 9 | 63 | |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах/ | **48** | **8** | **56** | |
| **Дундаж оноо:** | | | | **60.85** | |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Гаалийн хэргийн болон магадлан шинжилгээний чиглэлээр сургалтад хамрагдаж, ур чадвараа дээшлүүлэх | 100% | 15.0 | |
| 2. | Шинээр гарсан хууль, тогтоол, журмыг судалж, хууль эрх зүйн мэдлэгээ бие даан дээшлүүлэх | 90% | 13.5 | |
| **Дундаж оноо:** | | | **14.25** | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 6 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 6 | |

| | | | |
|---|---|---|---|
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| Дундаж оноо: | | **6.0** | |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 8 |
| Дундаж оноо: | | **7.33** |

## 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 60.85 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14.25 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | **6.0** |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7.33 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **88.43** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга***
Гаалийн төв лабораторийн дарга ................................ (С.Цэрэнчимэд)

..........................
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
***зөвшөөрсөн:***
Шинжээч-Гаалийн улсын байцаагч ................................ (О.Доржханд)

2024.12.10.............. (огноо)

***Үнэлгээг хянасан:***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч .................................... (Г.Энхтайван)

XII/20, 2024........(огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн
гаалийн улсын ахлах байцаагч .................................... (Ө.Тэгшээ)

2024.12.20..............(огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч***
Гаалийн ерөнхий газрын дарга .................................... (Р.Отгонжаргал)

..............................(огноо)